

ЗӨВЛӨХ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТУХАЙ ЗАРЛАЛ

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам нь “Атар газар эзэмшсэн түүхэн 60 жилийн техник, технологийн ололт амжилтын талаар судалгаа хийж өгүүлэл бичих, түүхчилсэн ном бүтээх” зөвлөхийн үйлчилгээ үзүүлэх хүсэлтэй этгээдийг мэдүүлгээ ирүүлэхийг урьж байна. Зөвлөхийн тендер шалгаруулалтыг бага үнийн аргаар зохион байгуулна.

1. Энэхүү зөвлөх үйлчилгээ нь Атар газар эзэмшсэн түүхэн 60 жилийн техник, технологийн ололт амжилтыг хөгжлийн үе шат бүрээр архивын тоо баримт, судалгаа, сурвалжлага дээр үндэслэсэн өгүүлэл, сурвалжлага бичиж, түүхчилсэн номын эх бэлтгэх, хэвлүүлэх ажлыг гүйцэтгэх болно. Үүнд:

- “Атрын – I аян”-ы техник, технологийн хөгжил дэвшлийн түүхчилсэн өгүүлэл бичих,
- “Атар - II аян”-ы техник технологийн дэвшлийн талаарх баримтат өгүүлэл, дурсамжийн эмхэтгэл бичих,
- “Атар – III аян ”-ы техник, технологийн шинэчлэлийг харуулсан өгүүлэл, сурвалжлага, туршлага, зөвлөмж бичих,
- Өнөө ба ирээдүйн газар тариалангийн техник, технологийн чиг хандлагыг тодорхойлсон өгүүлэл бичих,

2. Мэдүүлгээ ирүүлж буй хуулийн этгээд нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 14-16 дугаар зүйлд заасан шалгуур үзүүлэлт, шаардлагуудыг хангаж буйг нотлох дараах баримт бичгийг ирүүлнэ. Үүнд:

- Байгууллагын ерөнхий танилцуулга;
- Аж ахуй нэгжийн гэрчилгээний хуулбар;
- Эрдэм шинжилгээ, судалгааны чиглэлээр 3-аас доошгүй жил үйл ажиллагаа явуулсан ажлын талаарх туршлага;
- Газар тариалангийн эрдэм шинжилгээ, судалгааны чиглэлээр ажилладаг мэргэжлийн боловсон хүчний чадвар, туршлагын талаарх мэдээлэл;

Сонирхсон этгээд нэмэлт мэдээллийг **2019.08.06-ны 11:00 цагаас өмнө ажлын цагаар** авч болно. Тендерийг цахимаар зохион байгуулж байгаа учир **2019.08.08-ны өдрийн 11 цаг 00 минутын** дотор WWW.TENDER.GOV.MN сайтаар ирүүлнэ үү.

МОНГОЛ УЛС, УЛААНБААТАР ХОТ, ЭНХТАЙВАНЫ ӨРГӨН ЧӨЛӨӨ 16А,
ЗАСГИЙН ГАЗРЫН 9 ДҮГЭЭР БАЙР, А КОРПУС, ХХААХҮЯ-НЫ 503 ТООТ ӨРӨӨ.
УТАС: 263408

АЖЛЫН ДААЛГАВАР

Атар газар эзэмшсэн түүхэн 60 жилийн техник, технологийн ололт амжилтын талаар судалгаа хийж өгүүлэл бичих, түүхчилсэн ном бүтээх зөвлөх үйлчилгээний үйлчилгээний тендерийн ажлын даалгавар.

Ажлын хэмжээ: Атар газар эзэмшсэн түүхэн 60 жилийн техник, технологийн ололт амжилтыг хөгжлийн үе шат бүрээр тоо баримт, судалгаа, сурвалжлага дээр үндэслэн бичиж, түүхчилсэн номын эх бэлтгэж 1000 хувь хэвлүүлнэ.

№	Захиалагчийн шаардлага	Гүйцэтгэгчийн санал	Ажил гүйцэтгэх зөвлөхийн тоо
1.	“Атрын – I аян”-ы техник, технологийн хөгжил дэвшлийн түүхчилсэн өгүүлэл бичих,		
1.1.	Газар тариалангийн үйлдвэрлэлийн 1921-1976 оны хөгжил дэвшлийн үр дүнг фото зураг, архивын баримт судалгаанд үндэслэн тодорхойлсон өгүүлэл бичих,		
1.2.	Монгол оронд үр тариа боловсруулах үйлдвэрлэлийг хөгжүүлсэн ололт амжилтыг тоо баримтаар илэрхийлж , техникжилт , боловсон хүчний хангамжийг архивийн фото зураг, тоо баримтад тулгуурласан өгүүлэл бичих,		
1.3.	Энэ үед ажиллаж байсан ахмад мэргэжилтэн, инженер техникийн ажилтануудаас ярилцлага авч, дурсамж сурвалжлага бэлтгэсэн байна.		
2.	“Атар - II аян”-ы техник технологийн дэвшлийн талаарх баримтат өгүүлэл, дурсамж бичих		
2.1.	Монгол оронд газар тариалангийн үйлдвэрлэл эрчимтэй хөгжсөн 1976-1990 оны техник технологийн ололт, амжилтыг тодорхойлж бичих,		
2.2.	1976-1990 оны газар тариалангийн техник, технологийн онцлог түүхийг фото, судалгааны баримтаар харуулан тодорхойлсон өгүүлэл бичих,		
2.3.	Энэ хугацаанд ажиллаж байсан ахмад мэргэжилтэн, инженер техникийн ажилтануудаас ярилцлага авч, дурсамж сурвалжлага бэлтгэсэн байна.		
3.	“Атар – III аян ”-ы техник, технологийн шинэчлэлийг харуулсан өгүүлэл, сурвалжлага, туршлага зөвлөмж бичих,		
3.1.	Монгол орон зах зээлд шилжсэн 1990-2019 оны газар тариалангийн үйлдвэрлэлд шинэ техник технологи нэвтэрч, газар тариалангийн үйлдвэрлэл шинэ шатад дэвшсэн түүхэн ололт амжилтыг дүгнэсэн өгүүлэл бичих,		
3.2.	Техник , технологийн дэвшлийн шинэ үеийн ололтыг фото зураг, судалгаагаар баталгаажуулан харуулсан байна.		

3.3.	Газар тариалангийн дэвшилтэт техник, технологийг нэвтрүүлсэн тариалангийн бүс бүр дэхь ААН-ийн инженер, техникийн ажилтануудаас ярилцлага авч сурвалжлага бэлтгэн тэдний тэргүүн туршлагыг харуулсан зөвлөмж боловсруулсан байна.		
4.	Өнөө ба ирээдүйн газар тариалангийн техник, технологи		
4.1.	Монгол Улсын Засгийн газраас “Атар –III аян”-ыг үргэлжлүүлж, техник, технологийн шинэчлэл, ололт амжилтыг тодорхойлсон өгүүлэл бичих,		
4.2.	Газар тариалангийн техник, технологийн хөгжил, ирээдүйн чиг хандалгыг тодорхойлсон өгүүлэл бичих,		
5.	Атар газар эзэмшсэн түүхэн 60 жилийн техник, технологийн ололт амжилт ном хэвлүүлэх		
5.1	Судалгаа дүгнэлт, сурвалжлагыг нэгтгэн 15-20 хэвлэлийн хуудас номыг 1000 ширхэг хэвлүүлж захиалагчид хүлээлгэж өгнө.		